

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР ТАЙЛАН

Иргэдээс нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тухай
(2025 оны нэгдүгээр улирлын байдлаар)

2025.03.27

Багахангай дүүрэг

Тус дүүрэг нь "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай" хууль, Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/1049, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2023 оны өргөдөл, гомдлын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын хүрээнд ирүүлсэн зөвлөмж, Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/91 дүгээр захирамж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр хуралдааны тэмдэглэлийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.


2025 оны нэгдүгээр улирлын байдлаар иргэдээс 12 байгууллагад нийт 60 өргөдөл ирснээс 55 өргөдлийг хуулийн хугацаанд, 5 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна. Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100%-тай, дундаж хугацаа 5 хоног 15 цаг 40 минут байна.

Өргөдөл, гомдлын хандалтын эх үүсвэр


Хүснэгт №1

№	Эх үүсвэрүүд	Тоо	Хувь
1.	Нутгийн захиргааны байгууллага	49	89.1%
2.	Засгийн газрын 11-11 төв	6	10.9%
	Нийт	55	100%

Хүснэгт №2



Хүснэгт №3




Иргэдээс ирүүлсэн гомдолд дүн шинжилгээ хийхэд:

Дүүргийн хэмжээнд нутгийн захиргааны байгууллагаар 1, Засгийн газрын 11-11 төвөөр 1 гомдол нийт 2 гомдол ирүүлсэн байна. Үүнд Нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагааны тухай гомдол 1 буюу 50%, Нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн тухай гомдол 1 буюу 50%-ийг эзэлж байна.


Иргэдийн гомдлыг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж, хариуг албан бичгээр хүргүүлсэн байна.

Хүснэгт №4



Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад 3 байгууллага зөрчил гаргасан бөгөөд өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил 1, өдөрт багтаан шилжүүлээгүй 2, явцын тэмдэглэл хөтлөөгүй 2, нийт 5 зөрчил байна. Зөрчил гаргасан 3 байгууллагын 5 албан хаагчаар зөрчлийн шалтгаан нөхцлийн талаар тайлбар гаргуулан, цаашид өргөдлийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэхгүй байх, шийдвэрлэлтийн явцад зөрчил гаргахгүй байхад анхаарч ажиллахыг үүрэг чиглэл болгов.

Хүснэгт №5



Зөрчил гаргасан байгууллагуудыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт №6


№	Байгууллагын нэр	Зөрчлийн тоо	Үүнээс			
			Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	Явцын тэмдэглэл хөтлөөгүй	Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй
1.	Засаг даргын Тамгын газар	3	1	1	1	-
2.	Онцгой байдлын хэлтэс	1	1	-	-	-
3.	"Илч-Орд" ОНӨААТҮГ	1	-	-	1	-
Нийт		5	2	1	2	0

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар иргэнд хариу өгсөн хэлбэрээр нь авч үзвэл:

Хүснэгт №7

Шийдвэрлэсэн байдал	
Ангилал	Тоо
Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл	45
Боломжгүй тухай хариу өгсөн өргөдөл	9
Бусад	1

Хүснэгт №8



Иргэдээс нутгийн захиргааны байгууллагуудад ирүүлсэн өргөдөл, гомдлыг хандалтаараа дийлэнх хувийг эзэлж буй өргөдлийг авч үзвэл:

Хүснэгт №9

Д/д	Ангилал	Өргөдөл, гомдлын тоо	Өргөдөл гомдлын хувь
1	Ажилд орох тухай	13	21.66%
2	Ажилд орох хүсэлтийн тухай	10	16.66%
3	Ажлаас чөлөөлөгдөх тухай	4	6.90%
4	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай	4	6.90%
5	Нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагааны тухай	4	6.90%
6	Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албаны үйл ажиллагааны тухай	3	5.17%
7	Хоолны газар, баар, рестораны үйлчилгээний тухай	2	3.45%
8	Ажлын сахилга, хариуцлагын тухай	2	3.45%
9	Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай	1	1.72%
10	Бүртгэлийн салбарын үйл ажиллагааны тухай	1	1.72%
11	Дүүргийн Засаг даргын бодлого, үйл ажиллагааны тухай	1	1.72%
12	Тамхины зөвшөөрөл, худалдаа, үйлчилгээний тухай	1	1.72%
13	Цагдаагийн байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн тухай	1	1.72%
14	Хүүхэд үрчлэлийн асуудал	1	1.72%
15	Төсөл, хөтөлбөрт хамрагдах тухай	1	1.72%
16	Сургалтанд хамрагдах тухай	1	1.72%
17	Мөнгөн тусламж хүсэх тухай	1	1.72%
18	Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын тухай	1	1.72%
19	Орон сууц хүсэх тухай	1	1.72%

20	Байгаль орчны дүгнэлт гаргуулах тухай	1	1.72%
21	Сургалтын төлбөр хүсэх тухай	1	1.72%
22	Жирэмсний амралтын тухай	1	1.72%
23	Нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн тухай	1	1.72%
24	Явган хүний зам, талбайн тохижилтын тухай	1	1.72%
25	Цалин, хөлсний тухай	1	1.72%
26	Онцгой байдлын салбарын үйл ажиллагааны тухай	1	1.72%
Нийт		60	100%

Өргөдөл, гомдлын талаарх мэдээ мэдээллийг иргэдэд хүргэх, сурталчлах зорилгоор 1, 2 дугаар хороо болон Засаг даргын Тамгын газрын байранд “Өргөдөл, гомдлын мэдээлэл” самбар байршуулан, өргөдөл, гомдол хүлээн авах албан хаагчийн мэдээлэл, өргөдөл хүлээн авах эх үүсвэр, өргөдөл гаргахад шаардагдах мэдээллийн жагсаалт, удирдлагуудын иргэдтэй хийх уулзалтын хуваарийг тус тус байршуулав. Мөн дүүргийн веб сайт болох www.bagakhangai.ub.gov.mn сайтад тайлан мэдээг тухай бүр байршуулж байна.

Байгууллагын угтах үйлчилгээнд өргөдөл гомдлын мэдээллийг иргэдэд хүргэх дэлгэц байршуулж, өргөдөл, гомдлын явцын мэдээллийг тогтмол хүргэж хэвшээд байна.

ХЯНАСАН

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ



ТАЙЛАН ГАРГАСАН

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Н.БАТЦЭНГЭЛ